



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн “Замын-Үүдийн Дулааны станц” ТӨҮГ-ын
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн
аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2022/9/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.dornogovi@audit.gov.mn Сайншанд сум 2022 он	Дарга, Тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 261665, 70522734 Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn Аудитын менежер: У.Оюунтүлхүүр Утас: 70523020 Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn Аудитор: Т.Оюунтуяа Утас: 99048991 Цахим хаяг: oyuntuya@esanhuu.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (705) 2-27-34

Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

Догол. 03.15 № 16/329

танай _____ -ны № _____ -т

ЗАМЫН-ҮҮДИЙН ДУЛААНЫ
СТАНЦ ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ
О.ТӨМӨРХУЯГ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Замын-Үүдийн Дулааны станц ТӨҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Замын-Үүдийн Дулааны станц ТӨҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.ГАН-ӨЛЗИЙ



010020127

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	0	2,243.0
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	0	56,193.4
	Нийт хөрөнгийн дүн	0	58,436.4
	Нийт өр төлбөрийн дүн	0	17.7
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	0	58,418.7
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	0	58,436.4
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	0	3,255.4
	Үйл ажиллагааны зардлын дүн	0	3,283.6
	Үйл ажиллагааны үр дүн	0	(28.2)
	Үйл ажиллагааны бус үр дүн	0	0.1
	Үйл ажиллагааны нийт үр дүн	0	(28.3)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0	0
	Тайлант оны үр дүн	0	(28.3)
	Эцсийн үлдэгдэл	0	58,418.7
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	0	3,393.1
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	0	2,624.8
	Үйл ажиллагааны ЦМГ	0	768.3
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	0	(147.9)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	0	
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	0	620.3
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	620.3

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн “Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд Монгол Улсын Зам Тээвэр, Барилга хот байгуулалтын яам хамтран БНХАУ-ын “Чайна Камк Инженеринг” /СМЕС/-тай Замын-Үүдийн нутаг дэвсгэрт /87МВт/-н дулааны станц, 3050м3/хоног хүчин чадалтай ус цэвэршүүлэх үйлдвэр, 3040м3/хоног хүчин чадалтай бохир ус цэвэрлэх байгууламжийг барьж байгуулахаар ZU-05/09 тоот концессын гэрээг байгуулж ажилласан байна.

Дорноговь аймгийн “Замын-Үүдийн Дулааны станц” ТӨҮГ нь Монгол Улсын Засгийн Газрын 2020 оны 123 дугаар тогтоолоор байгуулагдсан бөгөөд Монгол Улсын Засгийн Газрын 2021 оны 11 дүгээр сарын 03-ны 338 дугаар тогтоолоор дүрэмдээ нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцэж байна.

Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бүрэлдэхүүн одоогоор томилогдоогүй байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3. “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;”-д заасны дагуу дотоод зохион байгуулалтын бүтцийг 2 үйлдвэрлэлийн үйл ажиллагааг ээлж дарааллан ажиллуулах төлөвлөгөөтэйгээр дулааны үйлдвэрлэл зогссон үед ус хангамж, ариутгах татуургын үйлдвэрлэлийг эхлүүлэхэд дулааны ажилчдыг шилжүүлэн ажиллуулахаар зохион байгуулж, чиг үүргийн давхардлыг арилгаж орон тоог 49 орон тоогоор бууруулсан, удирдлага болон албан хаагчдын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан шаталсан зарчмаар цалинг тогтоосон байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

Гурав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Тус байгууллагын Шилэн дансны цахим системд тайлант хугацаанд 654.8 сая төгрөгийн 33 гүйлгээний мэдээллийг хугацаа хоцроосон, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 792.9 сая төгрөгийн орлогын 7 гүйлгээ, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 336.9 сая төгрөгийн худалдан авалтын 10 гүйлгээ, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 13.2 сая төгрөгийн зарлагын 1 гүйлгээг мэдээлээгүй байна.

Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант хугацаанд нийт 376.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 11 бараа, ажил үйлчилгээг хөрөнгө оруулалтаар төлөвлөснөөс харьцуулалтын аргаар бараа нийлүүлэх 2 тендерээс нэг тендерийг Засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим хуудсанд 2021 оны 11 дүгээр сард байршуулж зарласан ба барааны худалдан авалтын төлбөрийг 9 дүгээр сард урьдчилан шилжүүлсэн, нөгөө тендерийг цахим системд зарлаагүйгээр худалдан авсан байна. Зарласан тендерийн үр дүнг санал ирүүлсэн оролцогч байхгүй гэж мэдээлсэн. Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4-т “захиалагч тендерийн урилгыг энэ хуулийн 52.1.12-т заасан цахим хуудсанд байрлуулж, тендер шалгаруулалтын дүнг тухай бүр мэдээлнэ” заалттай нийцэхгүй байна. Мөн тус компанийн худалдан авалтын төлөвлөгөөг эрх бүхий дээд байгууллагаар батлагдаагүй ба тендер шалгаруулалтын журмыг зөрчиж, 63.3 сая төгрөгийн бараа ажил үйлчилгээг шууд худалдан авсан нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 дүгээр заалтуудтай нийцэхгүй байна.

Дөрөв. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

Тав. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 311.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 311.2 сая төгрөгийн алдааг залруулж, 3 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 5 алдаа зөрчилд зөвлөмж өгсөн.

Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 311.2 сая төгрөгийн алдааг залрууллаа. Үүнд:

- Үндсэн хөрөнгийн тайлант хугацааны элэгдлийн зардлыг 311.2 сая төгрөгөөр илүү тооцож алдаатай бүртгэснийг залруулав.

Албан шаардлага

1. Тус байгууллагын Шилэн дансны цахим системд тайлант хугацаанд 654.8 сая төгрөгийн 33 гүйлгээний мэдээллийг хугацаа хоцроосон, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 792.9 сая төгрөгийн орлогын 7 гүйлгээ, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 336.9 сая төгрөгийн худалдан авалтын 10 гүйлгээ, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 13.2 сая төгрөгийн зарлагын 1 гүйлгээг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6.4.4-т *“таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”*, 6 дугаар зүйлийн 6.4.5-т *“...орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр...”* тус тус мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв

2. Тайлант хугацааны эцэст хөрөнгийн тооллого хийх тушаал шийдвэр гараагүй, тооллого хийгдээгүй байгаа нь Төрийн болон 70 дугаар зүйлийн 70.2-т *“Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж, улирал жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана”*, 70.2.1-т *“үндсэн хөрөнгө, ...тооллогыг жилд нэг удаа”*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.1 дэх хэсэгт *“Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна”*, 12.2-т *“дараах тохиолдолд заавал хийнэ”*, 12.2.1-т *“жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө”* гэж заасныг заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв

3. Жилийн эцэст 277.5 сая төгрөгийн авлагад тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д *“ерөнхий нягтлан бодогч нь... дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог ... баталгаажуулах”*, 20.2.6 *“ерөнхий нягтлан бодогч нь ...бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж...”* гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.Эргэлтийн бус хөрөнгөтэй холбоотой асуудал

1.1 **Илрүүлэлт:** Үндсэн хөрөнгийн бүртгэлд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 47 нэр төрлийн анхны дансны үнэтэй 98.3 сая төгрөгийн 48 ширхэг хөрөнгө “0” үлдэгдэлтэй байна. Энэ нь НББОУС 16 Үндсэн хөрөнгийн 51 дүгээр зүйлд тусгасан “Хөрөнгийн үлдэх өртөг ба ашиглалтын хугацааг санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үзэх ба хэрэв хүлээлт нь өмнөх тооцооллоос өөр байвал уг өөрчлөлтийг НББОУС 8 “Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа”-ны дагуу бүртгэнэ, 31 дүгээр зүйлд тусгасан “... дахин үнэлэгдсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ нь дансны үнээсээ материаллаг ялгаатай байвал цаашид дахин үнэлэх зайлшгүй шаардлагатай” заалттай нийцэхгүй байна.

1.2 **Өгсөн зөвлөмж:** Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг дахин үнэлүүлэх асуудлыг шийдвэрлэх.

2. Мөнгөн гүйлгээний данстай холбоотой асуудал:

2.1 **Илрүүлэлт:** 2021 онд аж ахуйн нэгж байгууллагуудаас и-баримтгүй 381.6 сая төгрөгийн худалдан авалт хийсэн нь үнэлгээ ба хуваарилалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүйгээс гадна НББ-н тухай хуулийн 3.1.3-д “анхан шатны баримт” гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог; 13.7-д “*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*” гэсэн заалтууд, НӨАТ-ын тухай хуулийн 4.1.14-т “*төлбөрийн баримт*” гэж тухайн төлбөр тооцоо хийгдсэнийг нотлох он, сар, өдөр, дахин давтагдашгүй төлбөрийн дугаар бүхий нэгдсэн системээр баталгаажсан, албан татвар суутган төлөгч буюу худалдаа эрхлэгчийг таних тэмдэг бүхий нэр, хаяг, татвар төлөгчийн дугаар, худалдаа хийгдсэн бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, төлбөр тооцооны болон татварын дүн зэрэг мэдээллийг агуулсан зориулалтын тоног төхөөрөмжөөс гаргасан цаасан болон цахим баримтыг”, 17.3.2-т “*бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно*”; 17.6-д “*Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй*” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

2.2 **Өгсөн зөвлөмж:** Худалдан авалтыг тооцоо хийгдсэн тухай бүрд нь цаасан болон цахим ибаримтыг үндэслэн санхүүгийн тайланд тусгаж ажиллах

3. Худалдан авалттай холбоотой асуудал:

3.1 **Илрүүлэлт:** Тайлант хугацаанд нийт 376.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 11 бараа, ажил үйлчилгээг хөрөнгө оруулалтаар төлөвлөснөөс харьцуулалтын аргаар бараа нийлүүлэх 2 тендерээс нэг тендерийг Засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим хуудсанд 2021 оны 11 дүгээр сард байршуулж зарласан ба барааны худалдан авалтын төлбөрийг 9 дүгээр сард урьдчилан шилжүүлсэн, нөгөө тендерийг цахим системд зарлаагүйгээр худалдан авсан байна. Зарласан тендерийн үр дүнг санал ирүүлсэн оролцогч байхгүй гэж мэдээлсэн. Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4-т “захиалагч тендерийн урилгыг энэ хуулийн 52.1.12-т заасан цахим хуудсанд байрлуулж, тендер шалгаруулалтын

дүнг тухай бүр мэдээлнэ” заалттай нийцэхгүй байна. Мөн тус компанийн худалдан авалтын төлөвлөгөөг эрх бүхий дээд байгууллагаар батлагдаагүй ба тендер шалгаруулалтын журмыг зөрчиж, 63.3 сая төгрөгийн бараа ажил үйлчилгээг шууд худалдан авсан нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 дүгээр заалтуудтай нийцэхгүй байна.

3.2 Өгсөн зөвлөмж: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн холбогдох зүйл, заалтыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллах.

4. Бараа материалын бүртгэл, тайлантай холбоотой асуудал

4.1 Илрүүлэлт: Тус байгууллагын нягтлан бодогч эд хариуцагчийн гаргасан тайланг хянаж, хүлээн аваагүй байна. Мөн 11 сарын сэлбэг хэрэгслийн тайланд өөр өөр дүнгээр худалдан авсан, өөр өөр техникт тавигдах 3 моторын ээлжийн үнийг нэгтгэн, дундаж үнээр орлогод бүртгэж, зарлагадсан. Энэ нь “Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “Үнэн зөв байх”, Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 347 тоот тушаалын хавсралтаар баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягт бөглөх заавар”-ын 3 дугаар зүйл 3.9-д “Бараа материалын тайлан НХМаягт БМ-9, Бараа материалын тайланг агуулахын нярав, эд хариуцагч нь аж ахуйн нэгж, байгууллагын бүртгэлийн бодлогын баримт бичигт заасан хугацаанд агуулахын бүртгэлд үндэслэн материалын нэр, төрөл тус бүрийн тоо хэмжээгээр нэгтгэн гаргана. Бараа материалын тайланг нярав, эд хариуцагч нар дээр хөтлөгдөж буй агуулахын бүртгэлтэй тулгаж, хүлээн авна”, байгууллагын НБББББ-ийн 5-д “Бараа материалын өртөг тооцоололт”, “...тухайн барааны өртгийг хариуцсан нягтлан бодогч тооцож гаргаад ерөнхий нягтлан бодогчид өгч хянуулан баталгаажуулсны дараа уг бараа материалыг батлуулсан өртгийн дүнгээр дансанд орлого авч, нягтлан бодох бүртгэлд тусгана”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д “Анхан шатны баримтад.....шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр....” гэсэн заалтыг зөрчсөн байна.

4.2 Өгсөн зөвлөмж: Холбогдох стандарт, тушаал, зааврын дагуу бараа материалыг орлого авч, зарлага гаргах, бараа материалын тайланд тавих хяналтыг сайжруулах, баталгаажуулах

5. Тушаал шийдвэрийн биелэлттэй холбоотой асуудал

5.1 Илрүүлэлт: Цалинтай холбоотой тушаал шийдвэрийн биелэлтийг хянаж, байгууллагын ажилчдын 12 дугаар сарын бодогдсон цалингаас зөвхөн үндсэн цалинг 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний цалингийн сан, захирлын тушаалтай тулгаж үзэхэд 65 ажилтны цалинг зөрүүтэй олгосон байна. Үүнд:

Компанийн удирдлага цалингийн 3 шатлал бүхий “Цалингийн хэмжээг шинэчлэн батлах тухай” А/50 дугаар тушаалыг 2021 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр баталсан ба түүнээс өмнө гаргасан ажилтнуудын цалингийн тушаалыг өөрчлөөгүйгээс цалингийн зөрүү арилаагүй, илүү дутуу олгогдож байна.

5.2 Өгсөн зөвлөмж: Цалинтай холбоотой тушаал, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих

6.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалтай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	+	+			+			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ								

6.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	9	311.2	1	311.2	-	-	3	-	5	-
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
	НИЙТ	9	311.2	1	311.2	-	-	3	-	5	-